



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 4014

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Захиргааны өрөнхий хуулийн 4.2.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Коронавируст халдварт /КОВИД-19/-ын батлагдсан болон сэжигтэй цогцыг оршуулахад баримтлах түр журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн газар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжилт аргазүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Д.Цогбадрах)-д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/412 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД


С. ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 04 дүгээр сарын 16 өдрийн
~~оффици~~ тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН БОЛОН СЭЖИГТЭЙ ЦОГЦСЫГ ОРШУУЛАХАД БАРИМТЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь коронавируст халдварт (КОВИД-19)-т өвчний батлагдсан болон сэжигтэй цогцсыг зөөж тээвэрлэх, хүлээж авах, хадгалах, салах ёс гүйцэтгэх, оршуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс нь оршуулгын үйл ажиллагаанд хяналт тавих, халдвартгуйжүүлэлт хийх, гүйцэтгэх ажлын хэсгийн баг томилж, багт ажиллах байгууллагуудын ажиллах чиг үүрэг, зааврыг боловсруулан баталж, мэдээлж хэрэгжүүлнэ.

Хоёр. Цогцсыг зөөвөрлөх, хадгалах

2.1. Эмнэлэгт коронавируст халдварт (КОВИД-19)-ын лабораторийн шинжилгээгээр (ПГУ) батлагдсан, эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй нас барсан хүний цогцсыг тухайн эмнэлгийн байгууллага нь оршуулгын үйл ажиллагаа явагдах хүртэл хугацаанд зөөвөрлөхгүйгээр хадгална.

2.2. Эмнэлэгт нас барсан тохиолдолд авах арга хэмжээ:

2.2.1. Эмнэлэгт коронавируст халдварт (КОВИД-19)-ын лабораторийн шинжилгээгээр (ПГУ) батлагдсан, эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй нас барсан хүний холбогдох мэдээллийг эрүүл мэндийн байгууллага нь харьяа онцгой комисс болон эрүүл мэндийн газарт мэдэгдэнэ;

2.2.2. Эрүүл мэндийн байгууллага цогцсыг шингэн нэвтрэхгүй зориулалтын уутанд хийнэ. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь цогцсыг цогцос хадгалах хэсэгт байршуулна. Нийслэлд тухайн дүүргийн онцгой комисстын хамтран ажиллах гэрээ байгуулсан оршуулах үйл ажиллагаа эрхлэх байгууллага зөөвөрлөх, хадгалах, чандарлах ажлыг зохион байгуулна;

2.3. Эмнэлгийн бус нөхцөлд нас барсан тохиолдолд авах арга хэмжээ:

2.3.1 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын лабораторийн шинжилгээгээр (ПГУ) батлагдсан, эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй эмнэлгийн бус нөхцөлд нас барсан тохиолдолд харьяа цагдаагийн газар, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ;

2.3.2. Онцгой комиссоос томилогдсон баг хувийн хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөж, цогцост үзлэг хийж, зориулалтын уутанд хийнэ;

2.3.3. Гадны нөлөөтэй нас баралт гэж сэжиглэсэн тохиолдолд цагдаагийн байгууллагаас шүүх шинжилгээний алба, газарт дуудлага өгч, хүргүүлнэ;

2.3.4. Гадны нөлөөгүй нас баралт гэж үзвэл нийслэлд тухайн дүүргийн онцгой комисстын хамтран ажиллах гэрээ байгуулсан оршуулах үйл ажиллагаа эрхлэх байгууллага зөөвөрлөх, хадгалах, чандарлах ажлыг зохион байгуулна.

2.4. Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь цогцсыг зөөвөрлөхдөө шингэн нэвтрэхгүй зориулалтын уутанд хийж, уутны гадаргууг халдвартгуйжүүлнэ.

2.5. Цогцыг уутанд хийх, цогцост хурч ажиллах, цогцыг зөөвөрлөх ажилтан хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөнө.

дээс хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн зөв, халдварт хамгааллын дэглэмийн дагуу өмсөх бусад хүмүүстэй хавьтад болохгүй байхаар зохион байгуулна.

2.6. Цогцыг зөөвөрлөсөн тохиолдол бүрт автомашин, дамнуурга, тэргэнцэр зэрэг эд зүйлсийг халдвартгүйжүүлнэ.

2.7. Эмнэлгийн цогцос хадгалах байр ачааллаа дийлэхгүй болсон тохиолдолд онцгой комисс нь цогцос хадгалах, зөөвөрлөх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагад хандаж нөөц тусгай хөргүүрт цогцыг аль болох богино хугацаанд зөөвөрлүүлэн хадгалуулж болно.

2.8. Журмын 2.7-д зааснаар хадгалсан болон зөөвөрлөсөн тохиолдолд гарах зардлыг ар гэр хариуцна.

2.9. Коронавируст халдварт (КОВИД-19)-аар нас барсан хүний цогцос хүлээж авсан, үзлэг шинжилгээ хийсэн өрөө тасалгаа, цогцос зөөвөрлөж оруулж ирсэн, хадгалсан өрөөг халдвартай буюу улаан бүс болгож "Улаан бүсийн тэмдэг" тавьж битүүмжилнэ.

2.10. Цогцос хадгалах байр, эмгэг судлалын тасгуудад хамгаалах хувцас тайлах өрөө, хэсэгтэй байна. Хувцас тайлах хэсэгт, гарын угаалтуур, гар халдвартгүйжүүлэгч, халдвартай хог хаягдлын шар уут бүхий 50 л-ээс дээш хэмжээтэй, хөлөөр онгойдог хогийн сав, эд зүйл болон гутал халдвартгүйжүүлэх усмал, хувцас солих шүүгээ, биеийг бутэн харах боломжтой толь, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, тайлах дарааллын зураг байрлуулсан байна.

2.11. Халдвартын сэргийлэлт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх журмын дагуу нэг чигийн урсгал хөдөлгөөний маршрутын зураглал заавар гаргасан байна.

2.12. Цогцос байршуулсан гадаргуу, хадгалсан хөргөгч, өрөө тасалгаанд голомтын эцсийн халдвартгүйжүүлэлтийг тухайн эмнэлгийн байгууллага хийнэ.

2.13. Нас барагчийн нас барах үедээ хэрэглэж байсан хувцас, бусад зөвлөн эдлэлийг шар өнгийн уутанд хийж, аюултай хог хаягдал устгах журмын дагуу устгана. Ар гэр авах хүсэлт гаргавал угаалгын нунтаг бүхий халуун усанд угаах, нарны гэрэлд хатааж, индуудэхийг зөвлөнө.

Гурав. Цогцос хадгалах, салах ёс гүйцэтгэх өрөөний халдвартын сэргийлэлт

3.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг салах ёс гүйцэтгэх өрөө, үйлчилгээний танхим, эмгэг судлалын тасгийн албан тасалгаа, цахилгаан шат, ариун цэврийн өрөө зэрэгт байршуулна.

3.2. Эмгэг судлалын тасагт халдвартгүйжүүлэх бодис, амны хаалт, нүүрний хаалт, бээлий, гар халдвартгүйжүүлэх спиртэн суурьтай бодис, гарын шингэн саван, гарын цаасан алчуур, цэвэрлэгээний материалын нөөцийг бүрдүүлнэ.

3.3. Эмгэг судлалын тасгийн ажлын байранд анхны тусламжийн иж бүрдэл, шүүлтүүртэй амны хаалт, нэг удаагийн халад, ус нэвтрэхгүй хормогч, ханцуивч, усны гутал, гар халдвартгүйжүүлэгч, бээлий зэрэг хамгаалах хувцас хэрэгсэл, халдвартай хог хаягдлын шар уут, бусад шаардлагатай хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байна.

3.4. Салах ёс гүйцэтгэхэд дараах халдвараас сэргийлэх дэглэм баримтална:

3.4.1. Ар гэрийнхэн цогцост хүрэхгүй, цогцосны уутыг нээхгүй байх;

3.4.2 .Хүн хооронд 1-1.5 метрээс доошгүй зай барих;

3.4.3. Салах ёс гүйцэтгэх үйл ажиллагаанд ар гэрийн 10 хүртэлх хүний төлөөлөл оролцуулах;

- 3.4.4. Нэг дор олон хүн бөөгнөрүүлэхгүй байх;
- 3.4.5. Ар гэрийн төлөөлөл амны хаалт, нэг удаагийн бээлий өмсөх;
- 3.4.6. Спиртэн суурьтай гар халдвартгүйжүүлэгч байршуулах;
- 3.4.7. Оролцогчдын гарыг халдвартгүйжүүлэх;
- 3.4.8. Агаар сэлгэлт сайн хийх, нэвт салхилуулах;
- 3.4.9. Шашны холбогдолтой дундаа хэрэглэдэг эд зүйлийг хоорондоо дамжуулахгүй байх;
- 3.4.10. Оршуулах үйл ажиллагаа дуусч, амны хаалт, бээлийг тайлсны дараа гараа савандаж угаах;

Дөрөв. Оршуулах үйл ажиллагаа

- 4.1. Цогцыг зориулалтын газарт чандарлах болон булшлах аргаар оршуулах бөгөөд ил тавьж оршуулахыг хориглоно.
- 4.2. Улс, нийслэл, тухайн орон нутгийн онцгой комисс нь мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн оршуулах шийдвэрийг гаргаж, цагдаа, хяналтын байгууллагын төлөөлөл оролцуулан хяналт тавих багийг томилно.
- 4.3. Коронавируст халдварт (Ковид-19)-ын батлагдсан болон сэжигтэйгээр эмнэлгийн бус нөхцөлд болон гэртээ нас барсан тохиолдолд голомтын эцсийн халдвартгүйжүүлэлтийг улс, нийслэл, тухайн орон нутгийн онцгой комисс мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 4.4. Цогцыг чандарлах үйл ажиллагааг гүйцэтгэж буй байгууллага цар тахлын үеийн хууль дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.
- 4.5. Булшлах аргаар оршуулах тохиолдолд цогцыг уутнаас гаргахгүйгээр цогцос хадгалах байранд хайрцагт хийнэ. Хайрцагны гадна талыг халдвартгүйжүүлж гаргана. Оршуулах үйл ажиллагааг хяналтын багийн удирдлага дор ар гэрийн төлөөлөл гүйцэтгэнэ.
- 4.6. Хайрцагтай цогцыг өргөх, таглах зэргээр хайрцаганд хүрэх ар гэрийн гишүүд болон оршуулах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажилчид амны хаалт, нэг удаагийн бээлийтэй байна.
- 4.7. Оршуулгын үйл ажиллагаанд оролцож буй гэр булийн гишүүдийн нэрсийн жагсаалт, холбоо барих утасны дугаарыг оршуулгын ёслолын өмнө өдөр бүртгэж авна. Гэр булийн гишүүд цогцост хүрэхийг хориглоно.
- 4.8. Оршуулгын үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүс хяналт тавих багийн хяналтанд амны хаалт, нэг удаагийн бээлийг тайлж, гараа угааж, халдвартгүйжүүлнэ.
- 4.9. Хяналтын баг оршуулгын үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж, багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Эмгэг судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг хариуцлага

- 5.1. Шалтгаан тодорхойгүй уушгины цочмог өвчинөөр нас барсан, коронавируст халдварт (КОВИД-19)-ын эмнэл зүйн болон тархвар зүйн холбогдолгүй цогцост эмгэг судлалын задлан шинжилгээг хийхдээ эмгэг судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтэн, туслах ажилтан хууль сахиулах байгууллагын албан хаагчид нүдний шил, нүүрний хаалт, усны гутал, урт ханцуйтай шингэн нэвтэрдэггүй халад, комбинзон, усны хамгаалалттай хормогч, шүүлтүүртэй амны хаалт, ахуйн бээлий өмсөнө.
- 5.2. Халдвартын эрсдэлтэй голомтод ажилласан багийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчид, халдвартын нууц үе илрэх хугацаанд /5-7 хоног/ гэрийн тусгаарлалтад байж, халдвартын шинж тэмдэг илрээгүй бол Коронавируст

халдвар (КОВИД-19) илрүүлэх ПГУ шинжилгээнд хамрагдаж шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд ажлын байрандаа эргэн орно.

**Зургаа. Эмгэг судлалын задлан шинжилгээ хийж байх явцад
Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй байдал илэрсэн тохиолдолд**

6.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан (ICD U.07.1), эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй тохиолдол (ICD U.07.2), уг өвчний хүндрэл нь үхлийн шалтгаан болж нас барсан гэж үзвэл өвчний олон улсын Хангиллын дагуу оношийг бичиж кодлон эмгэг судлалын задлан шинжилгээг хийхгүй.

6.2. Хэрвээ эмгэг судлаач эмч задлан шинжилгээ хийж байх явцад коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдолоор нас барсан байх магадлалтай бол мэргэжлийн байгууллагад мэдэгдэж тандалт судалгаа хийлгэх, зааварчилгаа авна.

6.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан болон эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй өвчтөн нас барсан үед цогцостой харьцан ажиллах, үзлэг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрсдлээс урьдчилан сэргийлж, цар тахлын бэлэн байдалд зохицуулан, хүний нөөцийн зохион байгуулалт хийнэ.

6.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан, сэжигтэй, ойрын хавьтал нас барсан тохиолдолд хэргийн газрын үзлэгт зайлшгүй оролцох шаардлагатай үед жолооч, криминалистикийн шинжээч шүүх эмнэлгийн шинжээч эмч, болон бусад албан хаагчид хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу бүрэн зөв өмсөнө.

6.5. Эмгэг судлалын задлан шинжилгээний явцад коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилсөн байх магадлалтай бол шинжилгээг бага хүрцтэй аутопсийн аргаар дуусгана.

6.6. Шингэн нэвтрэхгүй материал дэвсэж, цогцыг уутанд хийн, уутны бүх гадаргууг халдвартайжүүлэн, "Халдварын эрсдэлтэй" гэж тэмдэглэн цогцос хадгалах хэсэгт шилжүүлнэ.

6.7. Сэжигтэй тохиолдолдоор нас барсан хүний шарилыг ар гэрт таниулах, оршуулах зан үйлд бэлдэх, салах ёс гүйцэтгэх, ар гэрт болон оршуулгын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөхдөө хамгаалах хувцас хэрэгслийг өмсөнө.

6.8. Хэрэв коронавируст халдвар (КОВИД-19)-ын онош батлагдсан тохиолдолд цогцост задлан шинжилгээ хийхэд оролцсон албан хаагчдад эрсдэлийн үнэлгээ хийж хавьтал болсон гэж үзвэл эрүүл мэндийн байдлыг хянан, 10 хоног гэрээр тусгаарлана.

6.9. Цогцост задлан шинжилгээ хийх явцад сэжигтэй тохиолдолоор нас барсан байх магадлалтай бол дээжийг вирус судлалын лабораториид илгээж шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд, хими биологийн лаборатори руу шинжилгэдэхүүнийг илгээнэ.

6.10. Сэжигтэй тохиолдолд өмссөн хамгаалах хувцас хэрэгсэлийг зааврын дагуу тайлж, битүүмжлэн, эмнэлгийн халдвартай хог хаягдлыг устгах журмын дагуу хүлээлгэн өгнө.

Долоо. Бусад

7.1. Энэхүү журам нь улс орон, бус нутгийн хэмжээнд зарласан гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Журамд Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол шийдвэрт үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7.3. Энэ журмыг зөрчвэл “Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 17-р зүйлд заасны дагуу хариуцлага тооцно.

7.4. Зайлшгүй шаардлагын улмаас цогцост шинжилгээ хийх нөхцөлд Эмгэг судлалын үндэсний төвийн даргын тушаалаар эмч, туслах ажилтан томилогдож тухайн эмнэлэг, байгаа газарт нь шинжилгээ хийнэ.